WWW.KWU.AC.KR

2025 оны хичээлийн жилд Гванжу эмэгтэйчүүдийн их сургуулийн гадаад оюутны нэмэлт элсэлтийн журам

Гванжу эмэгтэйчүүдийн их сургууль

Гарчиг

[Баклаврын ангид гадаад оюутан элсүүлэх танилцуулга]

Ⅰ~Ⅱ. Тавигдах шаардлага / Элсэлт авах мэргэжлүүд ····· 2

Ⅲ. Мэргэжлүүдийн танилцуулга ····· 3~4

Ⅳ~Ⅴ. Элсэлтийн журам, сургалтын төлбөр ба тэтгэлэг...5~7

Ⅵ. Дотуур байр (Зөвхөн эмэгтэй оюутнуудад зориулсан).....7

Ⅶ. Бакалаврт элсэн ороход бүрдүүлэх бичиг баримт ····· 8

[Магистрын ангид гадаад оюутан элсүүлэх танилцуулга]

Ⅰ~Ⅲ. Элсэлтийн шаардлага / Элсэлт авах мэргэжлүүд /
Элсэлтийн журам ····· 9

Ⅳ. Сургалтын төлбөр ба тэтгэлэг ····· 10

Ⅴ. Мэргэжлүүдийн танилцуулга ····· 11~12

[Элсэгчийн анхаарах зүйлс] ····· 13

[Хотхоны газрын зураг, холбоо барих] ····· 14

2025 оны Гванжу Эмэгтэйчүүдийн их сургуулийн баклаврын түвшний гадаад оюутан элсүүлэх танилцуулга

Ⅰ. Тавигдах шаардлага

Ангилал	Боловсролын байдал
Солонгос хэлээр элсэгчийн шаардлага	1. Үндэсний Олон Улсын Боловсролын Хүрээлэнгийн зохион байгуулдаг Солонгос хэлний шалгалт (TOPIK) 3-р түвшин буюу түүнээс дээш, TOPIK IBT (цахим шалгалт) 3-р түвшин буюу түүнээс дээш 2. БНСУ-ын Нийгмийн нэгдсэн хөтөлбөр (KIIP)-ийн 3-р шат буюу түүнээс дээш түвшнийг амжилттай дүүргэсэн байх, Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн урьдчилсан үнэлгээнд (KIIP 사전평가) 61 болон түүнээс дээш оноо авсан байх. 3. Сэжун Хүрээлэн (세종학당)-гийн Солонгос хэлний дунд шатны 1-р түвшний сургалтыг амжилттай дүүргэсэн байх.
Англи хэлээр элсэгчийн шаардлага	1. Англи хэлийг төрөлх болон албан ёсны хэлээр ашигладаг орнуудын элсэлтийн нөхцөл: - Тухайн орнууд: АНУ (Америк), Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд, Ирланд, Өмнөд Африк - Хэрэв та англи хэлээр хичээл заадаг ахлах сургууль эсвэл түүнээс дээш түвшний сургуулийг төгссөн бол төгсөлтийн гэрчилгээ эсвэл холбогдох нотлох бичиг баримт гаргаж өгснөөр хэлний шалгалтыг орлуулах боломжтой. 2. Дараах англи хэлний шалгалтын онооноос дээш авсан байх шаардлагатай. - TOEFL(PBT 530, CBT 197, IBT 71, IELTS 5.5, TEPS 601(NEW TEPS 327) дээш
Бакалаврын шинэ элсэлт	1. Элсэгч болон эцэг, эх нь Солонгосын харьяат бус байх 2. Өөрийн эх орондоо болон гадаадад Солонгосын бага, дунд, ахлах сургуулийн түвшинд тохирох боловсролын хөтөлбөрийг бүрэн судалж, төгссөн (эсвэл төгсөх гэж буй) байх.
Бакалаврын шилжин суралцагч	1. Оюутан болон түүний эцэг, эх нь хоёулаа гадаадын иргэн байх 2. [3-р курс руу шууд шилжин суралцах] Солонгос эсвэл гадаадад бага, дунд боловсролын түвшинд Солонгосын боловсролын системтэй дүйцэхүйц сургалтыг бүрэн дүүргэсэн байх. Солонгос эсвэл гадаадын 4 жилийн сургалттай их, дээд сургуульд 2 болон түүнээс дээш жил суралцсан (эсвэл суралцаж байгаа). 3. [4-р курс руу шууд шилжин суралцах] албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулсан гадаадын их, дээд сургуулиудаас ирсэн оюутнууд

Ⅱ. Элсэх мэргэжил

Элсэлт	Салбар	Мэргэжил	Шинээр элсэх	Шилжин орох	Элсэх оюутны тоо
Солонгос хэлний анги	Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухаан	Агаарын тээврийн үйлчилгээ судлал - Агаарын тээврийн үйлчилгээ мэргэжил	-	O	хязгаартай
		Агаарын тээврийн үйлчилгээ	O	-	
		Цагдаагийн удирдлагын мэргэжил	O	O	
		Нийгмийн халамж	O	O	
		Сэтгэл судлалын мэргэжил	O	O	

		Олон улсын судлалын факультет – Солонгос хэлний боловсролын мэргэжил	-	O	
		Олон улсын судлалын факультет – Глобал Англи хэлний боловсролын мэргэжил	-	O	
		Олон улсын судлалын факультет – Менежментийн мэргэжил	-	O	
		Солонгос хэлний боловсролын мэргэжил	O	O	
	Байгалийн шинжлэх ухаан	Эрүүл мэндийн удирдлага	O	O	
		Хоол хүнс судлалын мэргэжил	O	-	
		Хиймэл оюун ухааны нэгдсэн судлал	-	O	
		Хиймэл оюун ухаан болон медиа контент	O	-	
		Гоо сайхны шинжлэх ухаан факультет – Гоо сайхны мэргэжил	O	O	
		Гоо сайхны шинжлэх ухаан факультет – Гоо сайхны бүтээгдэхүүний мэргэжил	O	O	
	Урлаг, биеийн тамир	Дотоод засал чимэглэл ба архитектурын дизайны мэргэжил	O	O	
		Спортын мэргэжил	O	O	
Англи хэлний анги	Хүмүүнлэгийн болон нийгмийн шинжлэх ухаан	Олон улсын хосолсон судлалын факультет – TESOL (Англи хэлний заах арга) мэргэжил	O	-	
		Олон улсын хосолсон судлалын факультет – IT болон бизнесийн хосолсон мэргэжил	O	-	
		Олон улсын хосолсон судлалын факультет – AI (Хиймэл оюун ухаан) ба их өгөгдөл (Big Data) мэргэжил	O	-	

Ⅲ. Мэргэжлийн танилцуулга

[Солонгос хэлний анги]

1. Агаарын тээврийн компанийн нислэгийн үйлчлэгч

– Зорилго: Нисэхийн салбарын практик ур чадвар эзэмшсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай нисэхийн мэргэжилтэн бэлтгэх

– Дотоод болон гадаадын агаарын тээврийн компанийн олон улсын нислэгийн үйлчлэгч 420 гаруй хүнийг амжилттай бэлтгэн гаргасан.

– Дотоод, гадаадын агаарын тээврийн компаниудад (нислэгийн үйлчлэгч, газар дээрх үйлчилгээний ажилтан) нийт 300 гаруй төгсөгчдийг бэлтгэн гаргасан.

2. Цагдаагийн удирдлагын мэргэжил

– Зорилго: Эмэгтэй цагдаа, хууль сахиулах байгууллагын мэргэжилтэн бэлтгэх

– Кэндо, Жүдо, Таеквондо, Хапкидо зэрэг тулааны урлагийн дадлага хийх боломжтой тусгай спортын заалтай

– Газар дээрх дадлага, төгсөгчдийн менторшип хөтөлбөр, цагдаагийн сорилго ярилцлага хийх боломж

3. Нийгмийн халамжийн анги

– Зорилго: Иргэдийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, нийгмийн халамжийн мэргэжлийн ажилтан бэлтгэх

– Олон нийтийн нийгмийн халамжийн төвүүд, Хүүхэд, өсвөр үеийн халамж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж, Ахмад настны халамж, Олон соёлт нийгмийн халамж, Төрөл бүрийн нийгмийн бүлэгт чиглэсэн бодит туршлага, практик чадварыг эзэмших боломжтой сургалт

4. Сэтгэл судлалын анги

– Зорилго: Бодит ажлын орчинд шаардлагатай сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх

– Төгссөний дараах ажиллах боломжтой салбарууд: Олон соёлт төв, Өсвөр үеийн зөвлөгөөний төв, Архины хамааралтай хүмүүсийн зөвлөгөөний төв, Эмэгтэйчүүдийн зөвлөгөөний төв, Их, дээд сургуулийн зөвлөгөөний төв, Гэр бүлийн хүчирхийллийн зөвлөгөөний төв, Хувийн сэтгэл зүйн зөвлөгөөний төв, Сэтгэл зүйн оношлогоо, боловсролын байгууллагуудад ажиллах боломжтой.

5. Олон улсын судлалын тэнхим

– **[Глобал англи хэлний боловсролын мэргэжил]** Хүүхдийн англи хэлний боловсрол (3-12 нас), Олон улсын англи хэлний боловсролын мэргэжилтэн бэлтгэх

※ TESOL (**Олон улсын англи хэлний багшийн эрх**), CETS-TESOL(**Олон улсын хүүхдийн англи хэлний багшийн эрх**), **Англи хэлний уншлагын удирдамжийн багшийн эрх** авах боломжтой.

– [Солонгос хэлний боловсролын анги]

Олон соёлт орчинд ажиллах чадвартай, хамт олноо манлайлсан солонгос хэлний мэргэжилтэн бэлтгэх, солонгос хэл, соёлыг олон улсад түгээх үйлсэд хувь нэмэр оруулах багш сургах, гадаад оюутнуудад болон цагаач иргэдэд солонгос хэл заах чадвар эзэмшүүлэх

※ Тус мэргэжлийг төгссөнөөр солонгос хэлний багшийн 2-р зэрэглэлийн эрх авах боломжтой.

– [Бизнесийн удирдлага]

Дотоод болон гадаадын олон улсын компаниудад шаардлагатай бодит чадвартай бизнесийн мэргэжилтэн бэлтгэх

Төгссөний дараах боломжит ажлын чиглэлүүд: Бараа бүтээгдэхүүний төлөвлөлтийн менежер, бизнесийн зөвлөх, олон нийтийн санал бодол судалгаа, анализ мэргэжилтэн гэх мэт

6. Солонгос хэлний боловсролын мэргэжил

Олон соёлт орчинд ажиллах чадвартай, хамт олноо манлайлсан солонгос хэлний мэргэжилтэн бэлтгэх, солонгос хэл, соёлыг олон улсад түгээх үйлсэд хувь нэмэр оруулах багш сургах, гадаад оюутнуудад болон цагаач иргэдэд солонгос хэл заах чадвар эзэмшүүлэх

※ Тус мэргэжлийг төгссөнөөр солонгос хэлний багшийн 2-р зэрэглэлийн эрх авах боломжтой.

7. Эрүүл мэндийн удирдлагын анги

– Зорилго: Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх

– Төгссөний дараах боломжит ажлын чиглэлүүд: Эрүүл мэндийн мэдээллийн менежер, эмнэлгийн удирдлага, менежер, эрүүл мэндийн судалгааны байгууллагын судлаач, эмнэлгийн үйлчилгээний зохицуулагч гэх мэт

8. Хүнсний контентын анги

– Зорилго: Хүнсний удирдлага, эрүүл ахуй, судалгаа хөгжүүлэлтийн мэргэжлийн мэдлэгийг эзэмшүүлэх, кофе, амттан (디저트), тэжээвэр амьтны хоол (펫푸드) зэрэг тусгай хүнсний бүтээгдэхүүн боловсруулах ур чадвар олгох, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, судалгаа, хөгжүүлэлтийн чиглэлээр ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэх

– Төгссөний дараах ажлын чиглэлүүд: Хүнсний чанарын хяналтын мэргэжилтэн, хүнсний бүтээгдэхүүн хөгжүүлэгч, бариста, тэжээвэр амьтдын хоол үйлдвэрлэл, хоол хүнсний контент бүтээгч

9. AI Медиа Контентын анги [Шинээр элсэгчдэд] / AI Нэгдсэн Технологийн анги [Шилжин суралцагчдад]

– Зорилго: Хиймэл оюун ухаан (AI), бодит мэдрэмжтэй медиа (AR/VR) чиглэлээр мэргэшсэн бүтээлч, чадварлаг эмэгтэй мэргэжилтэн бэлтгэх

– Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Big Data шинжээч, AR/VR контент хөгжүүлэгч, компьютер графикийн мэргэжилтэн

10. Гоо зүйн шинжлэх ухааны анги (Гоо сайхны мэргэжил / Гоо сайхны бүтээгдэхүүн)

– Зорилго: Арьс арчилгаа, үс засалт, нүүр будалт, хумсны урлаг, гоо сайхны бүтээгдэхүүний салбарт мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх

– БНСУ-ын анхны 4 жилийн гоо сайхны мэргэжлийн анги

Бакалавр · Магистр · Докторын зэрэгтэй сургалтын хөтөлбөртэй

– Төгссөний дараах ажиллах боломжууд:

[Боловсролын салбар] Гоо сайхан, гоо зүйн боловсролын байгууллагын багш, сургалтын хөтөлбөр хөгжүүлэгч

[Практик салбар] Үсчний салон, арьс арчилгааны салон, маникюрын салон, хуйх, үс уналтын арчилгааны төв, гэрлэх ёслолын студи, гоо сайхны судалгааны төв, Үнэртэн бүтээгч, гоо сайхны бүтээгдэхүүний брэнд менежер гэх мэт

11. Дотоод засал чимэглэл, архитектурын дизайн

– Зорилго: Дотоод орчны дизайны мэргэжилтэн, орон зайн менежментийн шинжээчээр мэргэжилтэн бэлтгэх

– Материал судлал, өнгө зохицол, тавилгын дизайн, гэрэлтүүлгийн дизайн, практик дизайн, компьютер дизайны ур чадвар гэх мэт

интерьер дизайны олон төрлийн мэргэжлүүдийн талаархи мэдлэг олгоно.
– Улсын хэмжээний дизайн уралдаанд оролцох, сайн дурын үйл ажиллагаанд оролцох, карьераа тасралтгүй хөгжүүлэх боломжтой.

12. Спортын анги

– Зорилго: Эмэгтэй спортын багш, спортын салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
– Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Өдөр тутмын амьдралын спортын багш, иог пилатесын багш, нөхөн сэргээх дасгалжуулагч, спортын маркетер гэх мэт.

[Англи хэлний анги]

1. Олон улсын анги

– **[Заавал судлах]** Хичээлийн эхний улиралд заавал судлах хичээлүүдийг судлаж дуусгасны дараа хоёрдугаар семестрээс эхлэн нарын мэргэжлийн хичээлийг сонгон суралцана.

– **[Олон улсын англи хэлний боловсролын анги]** Хүүхдийн англи хэлний заах арга зүйч (3~12нас), Олон улсын англи хэлний боловсролын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргадаг.
※ TESOL(Олон улсын англи хэлний багшийн үнэмлэх), CETS-TESOL(Олон улсын хүүхдийн англи хэлний багшын үнэмлэх), Англи хэлний чиглүүлэгч багшын гэрчилгээ зэрэг гэрчилгээ авах боломжтой.

– **[IT болон БИЗНЕС-ийн анги]** IT холболтын технологийг бизнесэд нэвтрүүлсэн шинэ төрлийн бизнес загварын сургалт, IT холболт менежментийн мэргэжилтнүүдийг бэлтгэх

– **[Хиймэл оюун ухаан (AI) ба их өгөгдлийн анги]** Компьютерийн мэдлэг болон логик сэтгэхүйтэй хиймэл оюун ухаан (AI) холболт болон их өгөгдлийн шинжилгээний мэргэжилтнүүдийг бэлтгэх

Ⅳ. Шалгаруулалтын заавар

1. Сонгон шалгаруулалтын өдөр

Ангилал	Өргөдөл хүлээн авах хугацаа	Сонгон шалгаруулалтын хугацаа	Тэнцсэн сурагчдыг зарлах хугацаа	Төлбөр төлөх хугацаа
Жилийн эцсийн-1р шат	2025. 3. 4.(Мя) ~ 4. 1.(Мя)	2025. 5. 12.(Да) ~ 5. 15.(Пү)	2025. 5. 16.(Ба)	2025. 5. 19.(Да) ~ 5. 23.(Ба)
Жилийн эцсийн-2р шат	2025. 5. 5.(Да) ~ 5. 23.(Ба)	2025. 6. 2.(Да) ~ 6. 13.(Ба)	2025. 6. 17.(Мя)	2025. 6. 30.(Да) ~7. 1.(Мя)
Жилийн эцсийн-3р шат	2025. 6. 9.(Да) ~6. 27.(Ба)	2025. 7. 7.(Да) ~7. 11.(Ба)	2025. 7. 18.(Ба)	2025. 7. 28.(Да) ~ 7. 29.(Мя)
Жилийн эцсийн-4р шат	2025. 7. 28.(Да) ~7. 31.(Пү)	2025. 8. 4.(Да) ~8. 8.(Ба)	2025. 8. 12.(Мя)	2025. 8. 21.(Пү) ~8. 22.(Ба)

Ⅴ. Сургалтын төлбөр болон тэтгэлэг

Ангилал	Салбар	Мэргэжил	Шинээр элсэгчийн сургалтын төлбөр (вон)	Шилжин ирэгчийн сургалтын төлбөр (вон)
Солонгос хэлний анги	Хүмүүнлэгийн салбар	Агаарын тээврийн үйлчилгээ судлал – Агаарын тээврийн үйлчилгээ мэргэжил	-	2,865,000
		Агаарын тээврийн үйлчилгээний анги	2,865,000	-
		Цагдаагын удирдлагын анги	2,865,000	2,865,000
		Нийгэм халамжийн анги	2,865,000	2,865,000
		Сэтгэл судлалын анги	2,865,000	2,865,000
		Олон улсын анги–Солонгос хэлний боловсролын анги	-	2,865,000
		Олон улсын анги – Глобал англи хэлний боловсролын анги	-	2,865,000
		Олон улсын анги – Бизнесийн удирдлагын анги	-	2,865,000
		Солонгос хэлний боловсролын анги	2,865,000	-
	Байгалын шинжлэх ухааны салбар	Эрүүл мэндийн удирдлагын анги	3,389,000	3,389,000
		Хүнсний контент судлалын анги	3,389,000	-
		AI нэгдсэн шинжлэх ухааны анги	-	3,389,000
		AI медиа контентийн анги	3,389,000	-
		Гоо зүйн шинжлэх ухааны анги– Гоо зүйн анги	3,781,000	3,781,000
		Гоо зүйн шинжлэх ухааны анги–Гоо сайхан бүтээгдэхүүний анги	3,781,000	3,781,000
	Урлагын салбар	Дотоод интерьер дизайны анги	3,389,000	3,389,000
		Спортын анги	3,389,000	-
Англи хэлний анги	Хүмүүнлэгийн салбар	Глобал хосолсон мэргэжлийн анги–TESOL мэргэжил	2,865,000	-
		Глобал хосолсон мэргэжлийн анги–IT Хосолсон Бизнесийн анги	2,865,000	
		Глобал хосолсон мэргэжлийн анги–AI & Big Data анги	2,865,000	

※ Дээрх сургалтын төлбөр нь 2025 оны хичээлийн жилийн үнэлгээгээр байгаа бөгөөд тогтоосон дүрэм журмын дагуу өөрчлөгдөж болзошгүй.

[Солонгос хэлний хөтөлбөрийн тэтгэлэгийн систем]

нэгж: вон(KRW)

Ангилал	Төрөл	Шаардлага	Түвшин	Тэтгэлэгийн хэмжээ
Баклавр	Шинэ оюутны тэтгэлэг	Баклаврт элсэж орохдоо TOPIK-ийн оноотой сурагч	TOPIK 3-р түвшингээс доош эсвэл KWU-TOPIK	Сургалтын төлбөрийн 30%
			TOPIK 3р түвшин	Сургалтын төлбөрийн 35%
			TOPIK 4р түвшин	Сургалтын төлбөрийн 50%
			TOPIK 5р түвшин	Сургалтын төлбөрийн 60%
			TOPIK 6р түвшин	Сургалтын төлбөрийн 70%
	Суралцаж буй оюутны тэтгэлэг	Дүнгийн тэтгэлэг (Өмнөх улиралын голч дүн 2.5-с дээш байх)	TOPIK 3р түвшингээс доош	Сургалтын төлбөрийн 20%
			TOPIK 3р түвшин	Сургалтын төлбөрийн 30%
			TOPIK 4р түвшин	Сургалтын төлбөрийн 50%
			TOPIK 5р түвшин	Сургалтын төлбөрийн 60%
			TOPIK 6р түвшин	Сургалтын төлбөрийн 70%

[Англи хэлний хөтөлбөрийн тэтгэлэгийн систем]

1. Англи хэлний хөтөлбөрт орсон албан ёсны хэлний чадварын гэрчилгээтэй оюутнууд

Англи хэлний оноо	Төрөл	Нөхцөл	Тэтгэлэг
IELTS 5.5, TOEFL(PBT 530, IBT 71, CBT 197), TEPS 601(NEW TEPS 327)	Шинэ оюутны тэтгэлэг	-	60%
Англи хэл нь төрийн хэл эсвэл албан ёсны хэлтэй улсын оюутнууд			
IELTS 5.5, TOEFL(PBT 530, IBT 71, CBT 197), TEPS 601(NEW TEPS 327)	Суралцаж буй оюутны тэтгэлэг	Өмнөх улирлын голч оноо 2.5-аас дээш	40%
IELTS 6.0, TOEFL(PBT 560, IBT 85, CBT 220), TEPS 650(NEW TEPS 355)			50%
IELTS 6.5, TOEFL(PBT 570, IBT 90, CBT 230), TEPS 701(NEW TEPS 387)			60%
IELTS 7.0, TOEFL(PBT 585, IBT 100, CBT 250), TEPS 750(NEW TEPS 419)			70%

2. Англи хэл нь эх хэл эсвэл албан ёсны хэлний нэг хэсэг болсон улс орнуудаас ирсэн оюутнууд: 2-8-р улирал (анхны улирлыг оролцуулахгүй)

Голч оноо	Тэтгэлэг олголт
3.0дээш~3.5доош	40%
3.5дээш~4.0доош	45%
4.0дээш~4.2доош	50%
4.2дээш~4.5доош	60%
4.5	70%

3. Бусад хөнгөлөлт (Солонгос хэлний хөтөлбөр, Англи хэлний хөтөлбөрийн нийтлэг зүйлс)

а. Эрүүл мэндийн даатгалын төлбөрийн хөнгөлөлт : 1 жилд 110,000 вон

б. Дотуур байрны төлбөрийн хөнгөлөлт : Шинээр болон шилжсэн оюутнуудын анхны улирал (16 долоо хоног) чөлөөлөгдөнө (4 хүнтэй өрөө, 483,000 вон)

4. Хэлний бэлтгэлтийн тэтгэлэг

а. Солонгос хэлний шалгалт (TOPIK) төлбөр болон авсан онооны тэтгэлэг олгох

Ангилал	TOPIK Ⅰ		TOPIK Ⅱ			
Шалгалтын төлбөрийн дэмжлэг	20,000원		27,000원			
Түвшин	**1-р түвшин**	**2-р түвшин**	**3-р түвшин**	**4-р түвшин**	**5-р түвшин**	**6-р түвшин**
Буцаан олголт	-	30,000вон	100,000вон	120,000вон	120,000вон	150,000вон

※ 2025 оны байдлаар дэлгэрэнгүй мэдээлэл нь TOPIK шалгалтын бүртгэлийн төлбөр болон авсан онооны урамшуулалыг хуваарийн дагуу олгоно.

Ⅵ. Оюутны дотуур байр (Эмэгтэй оюутнуудад зориулсан)

구분	기숙사비	기타사항
2 хүнтэй 1 өрөө	798,000вон / 16 долоо хоног	○ Ор, дэр нь хувийн бэлтгэл - Сургуулийн хүсэлт гарган тусдаа худалдан авах боломжтой ○ Хоолны төлбөр нь дотуур байрны төлбөрт орохгүй - Хоолны тасалбар тусдаа худалдаж авна
4 хүнтэй 1 өрөө	483,000вон / 16 долоо хоног	

※ 2025 оны байдлаар дотуур байрны дүрэм эсвэл амралтын улирлын хугацаанаас хамааран төлбөрийн хэмжээ өөрчлөгдөж болох юм.

Ⅶ. Баклаврын элсэлтийн бүрдүүлэх бичиг баримт

○ Шаардлагатай материал △ Зөвхөн шаардлага хангасан хүмүүст

№	Ангилал	Шинэ элсэгч	Шилжиж ирсэн	Тэмдэглэл
1	Элсэлтийн анкет	○	○	− Маягт татах: (Олон улсын харилцааны албаны вэбсайтын зар мэдээ хэсгээс) − globalgate.kwu.ac.kr → [유학생 입학] товчыг дарах → [모집요강/신청서] товчыг дарах
2	Сурах төлөвлөгөө	○	○	
3	Сургалтын төлбөр төлөх төлөвлөгөө	○	○	
4	Хувийн мэдээлэл ашиглах зөвшөөрөл	○	○	
5	Сүүлд төгссөн сургуулийн диплом болон дүнгийн тодорхойлолт	○	○	− Эх хувь болон орчуулсан хувилбарыг хураалгах ※ Эх хувиар 2 хувь: 1 хувийг сургуульд, 1 хувийг тухайн улсын ЭСЯ−д өгнө. − Дүнгийн тодорхойлолтонд асуудал байгаа тохиолдолд, сургуулийн тайлбар бичиг (Сургууль болон захиралын) эх хувиар хураалгах − Үндсэн нөхцөл: Хууль зүйн яамны зааварчилгааг дагах, **төгсөх оюутнууд нь төгссөн тухай гэрчилгээ болон сургуулийн боловсролын баталгаажуулсан гэрчилгээг бүрэн гаргаж өгөхөөс өмнө элсэлтийн зөвшөөрөл олгох боломжгүй.**
6	Боловсролын гэрчилгээ	○	○	1 Эх хувийг солонгос эсвэл англи хэлээр орчуулсан хувилбарыг хураалгах ※ Эх хувиар 2 хувь: 1 хувийг сургуульд, 1 хувийг тухайн улсын ЭСЯ−д өгнө. − Голлох улс орнууд: ※ Апостиль(Apostille) гэрээ байгуулсан орнууд: (БНХАУ, Монгол, Япон, Казахстан, Узбекистан гэх мэт)хураалгах ※ Апостиль(Apostille) гэрээ байгуулаагүй орнууд (Непал, Малайз, Вьетнам гэх мэт): Диплом, дүнгийн хуулгаа өөрийн улсын ЭСЯ эсвэл солонгосын ЭСЯ−аар баталгаажуулах шаардлагатай. ※ Хятад улс: Боловсролын баталгаажуулалтын төв (CHSI)-оос олгосон батламж i Хятад улсын мэргэжлийн дунд сургуулиудын гэрчилгээг зөвхөн сургууль гаргасан тохиолдолд нэмэлт баталгаажуулалах, орон нутгийн боловсролын байгууллагаас олгосон бол апостильтай байх төгсөлтийн урьдчилсан гэрчилгээг хүлээн зөвшөөрөхгүй ii Хятад улсын мэргэжлийн дунд сургууль (техникийн болон үйлдвэрийн сургууль): Хүний нөөц, нийгмийн хамгааллын яамны албан ёсны вэбсайтаас онлайнаар шалгаж болох баталгаажуулалтын хуудас + БНХАУ дахь БНСУ−ын ЭСЯ−ны баталгаажуулалт ※ Эх хувиар 2 хувь: 1 хувийг сургуульд, 1 хувийг тухайн улсын ЭСЯ эсвэл консулын баталгаажуулалт шаардлагатай. iii. Бусад ахлах сургууль төгссөнд тооцогдох сургууль: Сургууль өөрөө гаргасан төгссөн тухай гэрчилгээ+Апостиль баталгаажуулах
7	Сургуулийн тодорхойлолт	−	△	− Эх хувийг солонгос эсвэл англи хэлээр орчуулсан хувилбарыг хураалгах ※ Эх хувиар 2 хувь: 1 хувийг сургуульд, 1 хувийг тухайн улсын Элчин сайдын яаманд өгнө.
8	Гадаад паспорт (оюутан)	○	○	− Гадаад паспортын хуулбарыг хураалгах
9	Эцэг эхийн иргэний үнэмлэх	○	○	− Иргэний үнэмлэхний хуулбар хураалгах
10	Эцэг эхийн ажлын газрын болон орлогын тодорхойлолт	○	○	− Эх хувийг солонгос эсвэл англи хэлээр орчуулсан хувилбарыг хураалгах
11	Банкны баталгаа	○	○	− Эх хувиар хураалгах(Солонгос улсад оршин сууж байгаа тохиолдолд Солонгос дансанд банкны баталгаа гаргах) − **D2виз : 13,000$−с дээш (=16,000,000вон−с дээш) байна**
12	Төрөл садангын лавлагаа	△	△	− Эх хувийг солонгос эсвэл англи хэлээр орчуулсан хувилбарыг хураалгах − Эцэг эхийн аль нэг тал дахин гэрлэсэн тохиолдол (бичиг баримт дээрх овог өөр тохиолдолд) заавал төрөл садангын лавлагааг хураалгана. − Эцэг эх салсан тохиолдолд гэр бүл салсан лавлагааг эх хувиар хураалгах − Эцэг эх нас барсан тохиодолд нас барсны лавлагааг эх хувиар хураалгах
13	Цээж зураг 2ш(өнгөт)	○	○	− 3 X 4cm (цагаан фонтой байх)
14	Англи эсвэл солонгос хэлний (TOPIK)түвшин тогтоох шалгалтын оноо	○	○	− Англи хэлний хөтөлбөрт хамрагдагч: эх хувь 2 хуулбарыг бүрдүүлж өгнө. − Солонгос хэлний хөтөлбөрт хамрагдагч: эх хувь 2 хуулбарыг бүрдүүлж өгнө.
15	Гадаад иргэний үнэмлэх	△	△	− Хуулбарыг хураалгах (үнэмлэхний ард урд тал)

※ Визтэйгээр БНСУ-д оршин суугаа гадаадын иргэн бакалаврын элсэлтэд бүртгүүлэх тохиолдолд 9, 10, 12-р заалтыг алгасаж болно.

※ Гэхдээ дээрх нотлох баримтыг (1 ширхэг) анхдагч эх хувиар дахин авах боломжгүй тохиолдолд, эх хувь ба хуулбарыг нарийн шалган тулгасны дараа эх хувийг буцаан өгч, "эх хувийн хуулбар"-ыг нотлон баталгаажуулсан хувилбарыг бүрдүүлж өгнө.

2025 оны хичээлийн жилд Гванжу эмэгтэйчүүдийн их сургуулийн магистрын болон докторын хөтөлбөрт гадаад оюутан элсүүлэх тухай

Ⅰ. Тавигдах шаардлага

Ангилал	Боловсролын байдал
Иргэншил	Эцэг эх болон сурагч бүгд гадаадын иргэн байх
Боловсролын түвшин	[Магистр] Дотоод болон гадаадын их дээд сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан хүн [Доктор] Магистрын зэрэгтэй тэнцэх буюу түүнээс дээш эрдмийн зэрэгтэй гэж хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүн. [Нийтлэг нөхцөл] Хууль журмын дагуу дээрхтэй дүйцэх буюу түүнээс дээш боловсролтой гэж хүлээн зөвшөөрөгдсөн хүн
Солонгос хэл дээр суралцах чиглэл, нийтлэг шаардлага	1. TOPIK шалгалтын 3-р түвшин буюу түүнээс дээш (эсвэл TOPIK IBT шалгалтын 3-р түвшин) (Хэрэв боловсролын олон улсын чадавхи хангасан гэж хүлээн зөвшөөрөгдсөн их сургуульд элсэж байгаа бол тухайн сургууль дотооддоо зохион байгуулсан солонгос хэлний шалгалтаар 3-р түвшинг давсан бол) 2. Нийгмийн хөтөлбөрийн 3-р шат-ыг дүүргэсэн эсвэл урьдчилсан үнэлгээнд 61 ба түүнээс дээш оноо авсан байх 3. Сэжонгийн хүрээлэнгийн "Солонгос хэл - Дунд шат 1" түвшин буюу түүнээс дээш түвшний сургалтыг амжилттай дүүргэсэн хүн
Англи хэл дээр суралцах чиглэл, нийтлэг шаардлага	1. Англи хэлийг төрөлх хэл эсвэл албан ёсны хэлээр ашигладаг орнуудын иргэд - Хамаарах улс орнууд: АНУ, Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд, Ирланд, Өмнөд Африк - Англи хэлтэй улс орнуудын их, дээд сургуульд бакалавр эсвэл магистрын зэрэг эзэмшсэн бол англи хэлний түвшин тогтоох шалгалтын онооос чөлөөлөгдөх боломжтой. 2. Албан ёсны англи хэлний оноо: TOEFL 530 / CBT 197 / IBT 71, IELTS 5.5, CEFR B2 (162), TEPS 601 (NEW TEPS 327) ба түүнээс дээш

※ Бусад дэлгэрэнгүй мэдээллийг магистрантурын элсэлтийн гарын авлагаас харна уу

Ⅱ. Бүртгэл авах анги

Зэрэг	Ангилал		Танхим	Хичээлийн жил	Хичээлийн хуваарь	Элсэлт авах тоо
Доктор	Ерөнхий мэргэжлийн анги	Солонгос хэлний хөтөлбөр	Гоо зүйн технологийн анги	2жил	Өдөр	○○хүн
Магистр	Ерөнхий мэргэжлийн анги	Солонгос хэлний хөтөлбөр	Гоо зүйн технологийн анги Хүүхдийн англи хэлний боловсролын анги Нисэх аялал жуулчлалын анги Хүнс хоол тэжээлийн анги	2жил	Өдөр	○○хүн
	Нийгмийн хөгжлийн магистрын анги	Солонгос хэлний хөтөлбөр	Нийгэм халамжын анги Цагдаагын эрх зүйн анги Солонгос хэлний боловсролын анги	2жил	**Орой**	○○хүн
		Англи хэлний хөтөлбөр	Англи хэл заах арга зүй K-Гоо сайхны анги	2жил	**Орой**	○○хүн

Ⅲ. Элсэлтийн журам

1. Элсэлтийн хугацаа: Өмнөх оны 10-р сараас тухайн оны 1-р сар хүртэл
   Тухайн оны 6~7-р сар (Дэлгэрэнгүй мэдээллийг их сургуулийн магистрын элсэлтийн вэбсайтаас харна уу)
2. Материал хянах: Элсэлтийн анкет, апостиль, баклавр(магистрын) диплом(эсвэл төгсөх гэж буй), баклавр(магистрын) дүнгийн тодорхойлолт, топикын оноо зэргийг нэгтгэн дүгнэнэ.

Ⅳ. Сургалтын төлбөр болон тэтгэлэг

1. Сургалтын төлбөр Нэгж: Вон(KRW)

Ангилал	Салбар	Мэргэжлийн ангиуд	Шинээр элчэгч			Нийт
			Элсэлтийн хураамж	Сургалтын төлбөр	Өргөдлийн хураамж	
Доктор	Ерөнхий мэргэжлийн ангиуд	Гоо зүйн технологийн анги	600,000	5,139,000	50,000	5,789,000
Магистр	Ерөнхий мэргэжлийн ангиуд	Гоо зүйн технологийн анги		4,040,000		4,690,000
		Хүүхдийн англи хэлний боловсролын анги		3,390,000		4,040,000
		Нисэхийн аялал жуулчлалын анги		3,390,000		4,040,000
		Хүнс хоол тэжээлийн анги		4,040,000		4,690,000
	Нийгмийн хөгжлийн сургууль	Нийгэм халамжийн анги		3,129,000		3,779,000
		Цагдаагын хуулийн анги		3,129,000		3,779,000
		Солонгос хэлний боловсролын анги		3,129,000		3,779,000
				3,129,000		3,779,000
	Англи хэл дээрх сургалтын хөтөл бөр	Олон улсын англи хэлний багш бэлтгэх анги		3,360,000		3,960,000
		Гоо сайхан, гоо зүйн шинжлэх ухааны анги				

※ Дээрх сургалтын төлбөрийг 2025 оны хичээлийн жилийн байдлаар заасан бөгөөд өөрчлөгдөж болно

2. Тэтгэлэг

Тэтгэлгийн шалгуур	Тэтгэлэг	Бүрдүүлэх бичиг баримт	Бусад
TOPIK 3급 이하	Хичээлийн төлбөрийн 30% тэтгэлэг	TOPIK онооны гэрчилгээ	Зөвхөн БНСУ-ын Үндэсний Олон Улсын Боловсролын Хүрээлэнгээс зохион байгуулдаг TOPIK шалгалтын оноо
TOPIK 4급	Хичээлийн төлбөрийн 50% тэтгэлэг		
TOPIK 5급	Хичээлийн төлбөрийн 60% тэтгэлэг		
TOPIK 6급	Хичээлийн төлбөрийн 70% тэтгэлэг		
IELTS 5.5, TOEFL 530, IBT 71, CBT 197, TEPS 601(NEW TEPS 327), CEFR B2(Score 162-168)	Хичээлийн төлбөрийн 40% тэтгэлэг	Англи хэлний түвшин тогтоох шалгалтын оноо	
IELTS 6.0, TOEFL 560, IBT 85, CBT 220, TEPS 650(NEW TEPS 355), CEFR B2(Score 169-175)	Хичээлийн төлбөрийн 50% тэтгэлэг		
IELTS 6.5, TOEFL 570, IBT 90, CBT 230, TEPS 701(NEW TEPS 387), CEFR B2/C1(Score 176-184)	Хичээлийн төлбөрийн 60% тэтгэлэг		
IELTS 7.0, TOEFL 585, IBT 100, CBT 250, TEPS 750(NEW TEPS 419), CEFR C1(Score 185-)	Хичээлийн төлбөрийн 70% тэтгэлэг		
Англи хэлийг төрөлх хэл эсвэл албан ёсны хэлээр ашигладаг улсын оюутан	Хичээлийн төлбөрийн 50% тэтгэлэг		

※ Дээрх тэтгэлэг нь 2025 оны хичээлийн жилийн журмыг үндэслэн олгогдох бөгөөд дүрэм, журмын өөрчлөлтөөс хамаарч өөрчлөгдөх боломжтой.

Ⅴ. Мэргэжлүүдийн танилцуулга

1. Гоо сайхны шинжлэх ухааны тэнхим - Магистр болон Докторын анги

Ерөнхий сургуулийн Гоо сайхны шинжлэх ухааны тэнхим нь 2002 онд гоо сайхны дээд боловсролыг нээсэн цагаасаа хойш, 2007 онд магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрүүдийг албан ёсоор эхлүүлж, гоо сайхны цэвэр академик судалгааг гүнзгийрүүлэх онцлог бүхий мэргэжлийн сургуулиар хөгжиж ирсэн.

Энэхүү тэнхим нь: Судалгаанд суурилсан онолын сургалт ба бодит мэргэжлийн ур чадварын дадлага-г хослуулсан тогтолцоотойгоор сургалт явуулдаг. Гоо сайхны онол болон практикий уялдуулан, багш, сурган хүмүүжүүлэгч, мөн үс, арьс арчилгаа, нүүр будалт, хумс арчилгаа, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг салбарын мэргэжилтэнүүдийг бэлтгэдэг.

Оюутнууд нь үс засал, арьс арчилгаа, нүүр будалт, гоо сайхны бүтээгдэхүүний судлал зэрэг агуулгатай хичээлийн хөтөлбөрийг судалж, гоо сайхны салбарын байгууллагуудтай хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх боломжтой. Мөн гоо сайхны судалгааны төв болон клиник арьс судлалын төвөөр дамжуулан судалгаа, сургалт явагддаг. Энэ нь оюутнуудын гоо сайхны мэргэжлийн мэдлэг, судалгаа шинжилгээний чадамжийг хөгжүүлж, урлагийн бүтээлч сэтгэлгээг дэмжих боловсролын тогтолцоог бүрдүүлэн, гоо сайхны салбарын судлаач, бүтээлч мэргэжилтэн, удирдагчдыг бэлтгэх зорилготой.

2. Хүүхдийн англи хэлний боловсролын магистрын анги

Энэхүү тэнхимийн зорилго нь англи хэлийг олон улсын харилцааны ерөнхий хэл хэлбэрээр бага наснаасаа хялбархан сурдаг онцлогт тулгуурлан, шинжлэх ухааны, системтэй сургалтын хөтөлбөрөөр дамжуулан дараах чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэхэд оршино.

Үүнд: Хүүхдэд англи хэл заах арга зүй, заах шат дараалал, хичээл заах арга барил, олон төрлийн сургалтын үйл ажиллагаа боловсруулах, бодит сургалтын орчинд хэрэгжүүлж чадах практик аргачлал эзэмшүүлэх, ингэснээр хүүхдийн англи хэлний боловсролын салбарт чадварлаг, мэргэжлийн багш бэлтгэхийг зорьдог.

3. Агаарын тээвэр ба аялал жуулчлалын магистрын анги

Ерөнхий сургуулийн Агаарын тээвэр ба аялал жуулчлалын магистрын анги нь БНСУ-ын дэлхийн 8 том агаарын тээврийн гүрний нэг болж, олон улсын нисэхийн зах зээлд чухал байр суурь эзэлдэг. Ковид-19 цар тахлын дараах эндемик нөхцөл байдалд тус улсын нисэхийн салбар дахин хурдацтай сэргэж байна. Тус тэнхим нь дотооддоо хамгийн олон агаарын тээврийн мэргэжилтэн бэлтгэдэгээрээ танигдсан бөгөөд илүү мэргэжлийн, судалгаанд суурилсан, шинжлэх ухааны боловсрол олгохын тулд магистрын сургалтын хөтөлбөрийг нээсэн. Агаарын тээвэр ба аялал жуулчлалын хөгжлийн чиглэлээр: Илүү гүнзгий онолын мэдлэг эзэмшүүлэх, салбар хоорондын нэгдмэл судалгааны чадамжыг хөгжүүлэх, салбарын шинэчлэл, ирээдүйн өөрчлөлтөд

хариу өгөх чадвартай Шинэ нийгмийг манлайлах мэргэжилтэн бэлтгэх зорилгоор сургалт, судалгааг явуулдаг. Төгсөгчдийн чиглэл: Агаарын тээвэр ба аялал жуулчлалын салбарын судлаач, их сургуулийн профессор, зөвлөх мэргэжилтэн гэх мэт чиглэлээр карьераа үргэлжлүүлэх боломжтой.

4. Хүнс, хоол тэжээлийн тэнхмийн магистрын анги

Ерөнхий сургуулийн Хүнс, шим тэжээлийн магистрын анги нь хүнс, шим тэжээл, хоолны урлаг, гадуур хооллолт зэрэг салбарт шинэлэг сэтгэлгээтэй, бодитоор ажиллах чадвартай судлаач (Total Manager) бэлтгэх зорилготой. Онцлог: Fun & Creative сургалтын системтэй. Тус салбар бүрийн туршлагатай профессоруудаас бүрдсэн багшлах бүрэлдэхүүнтэй. Туршилт, дадлагын өргөн боломж бүхий дэд бүтцээр хангагдсан.

Судалгааны чиглэл: Орон нутгийн онцлог бүтээгдэхүүнийг ашиглан: Хүнсний чанарын шинж, биологийн идэвхтэй нэгдэл, хоолны боловсруулалтын онцлог, гадуур хооллолтын зах зээлийн зан төлөв ба идэвхжүүлэх стратеги зэрэг сэдвийг гүнзгийрүүлэн судална. Эзэмших зэрэг: Шинжлэх ухааны магистраар төгсөөд хүнс, хоолны салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийг дээшлүүлэх, орон нутгийн болон улсын хөгжлийг дэмжих чадварлаг хүний нөөц болон төлөв шүүлэхийг зорьдог.

5. Нийгэм халамжын магистрын анги

Нийгмийн халамжийн тэнхим нь хүн бүрийн аз жаргал болон амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор, асуудалтай хувь хүн, гэр бүл, бүлэг, орон нутгийн хамт олонд шаардлагатай тусламжийг үзүүлж чадах мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэдэг.

Сургалтын агуулга: Нийгмийн халамжийн онол ба бодлого, тогтолцоо

Судалгааны арга зүй: Нийгмийн халамжийн практик ур чадвар, орон нутгийн төвшинд дадлага хийх боломжтой. Онол ба практикийг хослуулан зааснаар, мэргэжлийн ёс зүйтэй, бодит нөхцөлд ажиллах чадвартай нийгмийн халамжийн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэдэг.

6. Цагдаагын эрх зүйн магистрын анги

Нийгмийн хөгжлийн сургууль - Цагдаа, хууль зүйн тэнхим нь төрийн болон хувийн хэвшлийн цагдаа, хамгаалалтын ажилтнуудад зориулсан мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор байгуулагдсан. 21-р зууны хөгжингүй цагдаагийн загварыг төлөвшүүлэх, цагдаагийн хууль, бодлого, тогтолцооны талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шуурхай хариу үзүүлэх чадамжийг олгоно. Аюулгүй байдлын систем зохион байгуулах, эрсдэл үнэлэх, хариу арга хэмжээ боловсруулах, хамгаалалтын бодлого хэрэгжүүлэх ур чадварыг эзэмшүүлнэ.

Сургалтын агуулга: Хууль эрх зүйн онол ба практик мэдлэг, гэмт хэрэг, нийгмийн асуудал, аюулгүй байдлын менежмент гэх мэт. Төр, хувийн хэвшлийн аюулгүй байдлын тогтолцоо: Энэхүү хөтөлбөр нь нийтийн болон хувийн хэвшлийн аюулгүй байдлын салбарт ажиллах шинэлэг сэтгэлгээтэй, манлайлагч мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чиглэнэ.

7. Солонгос хэлний боловсролын магистрын анги

Солонгос хэлний боловсролын тэнхим нь гадаад хэлний анги учир Солонгос хэлийг заах арга зүйн талаар тусгай мэдлэг эзэмшиж, Солонгос улсын соёлын талаар гүнзгий судалж мэдсэн мэдлэгтэй, Солонгос хэл болон соёлын даяаршилд хувь нэмрээ оруулах чадвартай боловсон хүчинг бэлтгэн гаргах зорилготой. Бид сурагчдын хэрэгцээнд нийцсэн практик сургалт, гадаад, дотоодын олон арга барилыг ашиглан Солонгос хэлний багшийн мэргэжлийн заах, судлах чадварыг хөгжүүлдэг. Солонгос хэлний боловсролын мэргэжлээр суралцаж төгссөнөөр 2-р түвшний Солонгос хэлний багшийн гэрчилгээ авах боломжтой.

8. (Англи хэлний хөтөлбөр) TESOL тэнхимийн магистрын сургалт

Англи хэл нь төрөлх хэл биш хүмүүст англи хэлийг үр дүнтэй заах чадвартай англи хэлний боловсролын мэргэжилтэн бэлтгэх бөгөөд англи хэл заах аргачлал, заах үйл явц, заах арга техник, төрөл бүрийн үйл ажиллагаа болон практик заах аргуудыг сургалтын орчинд хэрэгжүүлэх чадамжтай, олон улсын чиг хандлагад нийцсэн чадварлаг англи хэлний мэргэжилтэн бэлтгэх зорилготой.

9. (Англи хэл дээрх хөтөлбөр) K-Beauty магистрын хөтөлбөр

K-Beauty нь дэлхий дахинд хурдацтайгаар өсөн хөгжиж байгаа бөгөөд Солонгосын гоо сайхны бүтээгдэхүүн, нүүр будалт, арьс арчилгааны технологи нь олон улсын гоо сайхны салбарт өндөр үнэлгээтэй байдаг. K-Beauty-гийн эх оронд хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, практик төвтэй боловсролыг санал болгож, гадаад оюутнуудад зориулсан тохирсон олон улсын сургалтын орчныг бүрдүүлдэг. Ингэснээр дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай K-Beauty мэргэжилтэн бэлтгэнэ.

Элсэгчийн анхаарах зүйлс

1. Элсэгчийн анхаарах зүйлс

- Бүртгүүлэгч нь энэ элсэлтийн журамд заасан мэдээллийг сайтар уншиж танилцан, өргөдөл гаргах болон элсэлтийн шат дамжлагад ямар нэг алдаа гаргахгүй байх ёстой. Элсэлтийн журамд тусгагдаагүй бусад асуудлыг их сургуулийн дүрэм, журамд үндэслэн шийдвэрлэнэ.
- Бүртгэлийн материалыг хуурамчаар үйлдсэн буюу өөрчилсөн нь тогтоогдвол элсэлтийг хүчингүй болгоно.

  Бүх бичиг баримтыг үнэн зөв, нарийн бүрдүүлэх шаардлагатай бөгөөд үүнээс үүдэн гарах аливаа хохирлын хариуцлага нь бүртгүүлэгч өөрт нь ногдоно.
- Бичиг баримт дутуу бүрдүүлсэн болон элсэх болзол хангаагүй оюутныг бүртгэхгүй, шалгалтад тэнцээгүйд тооцно.
- **Бүртгүүлэх үед ирүүлсэн бичиг баримтыг ямар ч нөхцөлд буцаан өгөхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт материал шаардах боломжтой.**
- **Хүлээн авсан элсэлтийн өргөдлийг засварлах, цуцлах боломжгүй бөгөөд бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.**
- Элсэлтийн эрхээ авсан тохиолдолд, хэрэв эцэст нь БНСУ-д нэвтрэх виз олгогдохгүй бо тухайн элсэлтийг цуцалж болно.

Хувийн мэдээлэл цуглуулалт ба ашиглалт

- Сургуулийн элсэлтийн бүртгэл, шалгалтын үйл явцад доорх байдлаар хувийн мэдээллийг цуглуулж, ашиглаж болно.
- Шалгуулагчийн мэдээлэл: Нэр, хаяг, (гар утасны) дугаар, имэйл, сурагчийн мэдээлэл, төгссөн / төгсөх он, дансны мэдээлэл гэх мэт
- Эцэг эх (асран хамгаалагч)-ийн мэдээлэл: Нэр, харилцаа, хаяг, (гар утасны) дугаар гэх мэт
- Сургуулийн мэдээлэл: Төгссөн сургуулийн нэр
- Цуглуулсан хувийн мэдээллийг зөвхөн сургуулийн элсэлт, тэтгэлэг, хичээлийн болон статистикийн үйл ажиллагаа, сургуулийн талаарх мэдээлэл хүргэх зорилгоор ашиглах бөгөөд бусад зорилгоор ашиглахгүй. Хувийн мэдээлэл хадгалах хугацаа дуусах, эсвэл хэрэгцээгүй болсон тохиолдолд нэн даруй устгана.
- Дэлгэрэнгүйг "Хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах, олгох зөвшөөрлийн хуудас"-аас харна уу.

Сургуулийн хотхоны газрын зураг



1-р байр: Mu-deng gwan
2-р байр: Hwang-ryong gwan
3-р байр: O-deung gwan
4-р байр:
Information Communication Center

- Их сургуулиййн төв байр
- Номын сан
- Биеийн тамирын талбай
- Дотуур байр
- Биеийн тамирын заал

Холбоо барих

주소 (우편번호)62396, 광주광역시 광산구 광주여대길 22 광주여자대학교 국제교류처

Address (Zip code)62396, International Education Center, 22 Gwangju yeodae-gil, Gwangsan-gu, Gwangju,KOREA

Email kwuiec@kwu.ac.kr

Tel (한국어트랙) +82-62-950-3576
(영어트랙) +82-62-950-3930